

## **ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН УУЛЗАЛТАНД ГИШҮҮН ОРНУУДЫН ТУЛГАМДСАН АСУУДЛЫН ТУХАЙ**

2008 оны 8-р сарын 28-нд Бүгд Найрамдах Тажикистан улсын нийслэл Душанбе хотноо Шанхай Хамтын Ажиллагааны Байгууллагын дээд хэмжээний уулзалтанд гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн уулзалт болж өндөрлөв.

Уулзалтын энэ үеэр эрчим хүч, тээвэр, аюулгүй байдал, терроризмтэй тэмцэх асуудлаас гадна Өмнөд Осети болон Абхазын асуудалд нэлээд анхаарал хандуулан, мөн Ираныг ШХАБ-ын бүрэн эрхт гишүүн болгох асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн ажиглагчдын үзэж байгаагаар энэ удаагийн уулзалтаар нэлээд тулгамдсан асуудлууд хэлэлцэв. БНХАУ-ын дарга Ху Жинтао, ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев, Казахстаны Ерөнхийлөгч Н.А.Назарбаев, Киргизийн Ерөнхийлөгч К.С.Бакиев, Тажикистаны Ерөнхийлөгч Э.Рахмон, Узбекистаны Ерөнхийлөгч И.А.Каримов нар улс орноо төлөөлөн оролцсон юм. ШХАБ-ын ажиглагч орнуудаас Иран, БНЭУ, Монгол, Пакистан, хүндэт зочноор БНАфУ-ын Ерөнхийлөгч Х.Карзай, НҮБ, Евро-Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн төлөөлөгч уригдан оролцсон. ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев Өмнөд Осети болон Абхазын тусгаар тогтнолыг дэмжихийг гишүүн орнуудаас хүссэн боловч БНХАУ-ын эрх баригчид энэ асуудлаар байр сууриа тодорхой илэрхийлсэнгүй. Харин Казахстан зэрэг орон ОХУ-ын байр суурийг дэмжиж байгаагаа мэдэгдсэн юм.

ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Душанбегийн тунхаглал гаргасан, мөн Ираныг ШХАБ-ын бүрэн эрхт гишүүнээр элсүүлэх явдал ОХУ нь үндсэндээ Ираныг дэмжсэн ч Өмнөд Осети, Абхазын асуудлаас болж ОХУ, АНУ-ын харилцаа нэлээд ээдрээтэй байгаа нь сөргөөр нөлөөлж ШХАБ-ын бас нэгэн нөлөө бүхий гишүүн орон БНХАУ нь Ираныг бүс нутагтаа нөлөөтэй болгох хүсэлгүй байв. Тиймээс БНХАУ, Казахстан, Узбекистан нь үүнийг нь дэмжсэнгүй.

Тус байгууллагын гишүүн орнууд тулгамдсан асуудлаар өөр, өөр байр сууртай байв.

Энэ удаагийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийг төлөөлөн Гадаад Хэргийн сайд С.Оюун оролцсон бөгөөд Монгол Улс ШХАБ-тай цаашид хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлж мөн бүс нутагт энэ байгууллагын гишүүн болон ажиглагч орнуудтай дэд бүтэц, эрчим хүчний салбарт тодорхой чиглэлүүдээр харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Гадаад Хэргийн сайд С.Оюун, Тажикистан Улсын Ерөнхий сайд, ОХУ-ын Гадаад Хэргийн сайд С.Лавров, БНЭУ-ын Газрын тос, байгалийн хийн үйлдвэрийн сайд М.Деора нартай ажлын уулзалт хийж улс орны төрийн дотоод байдал, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцсон юм.

*Мэдээ бэлтгэсэн Г.Онон (ОУСХ-ийн эрдэм  
шинжилгээний ажилтан)*